



СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК

Монголын МНБИ болон ТМЗН-ийн гишүүн байгууллага

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“АКСИС КАПИТАЛ ББСБ” ХХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр

тасалбар болгосон санхүүгийн жил

Улаанбаатар хот

2025 он

УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

Компанийн удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Бадрах овогтой Бат-Орших Гүйцэтгэх Захирал, овогтой Ерөнхий нягтлан бодогчийн хувьд бид ард хавсаргасан 4-ээс 27-р хуудас дахь “Аксис Капитал ББСБ” ХХКомпанийн санхүүгийн тайлангуудыг холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх Компанийн санхүүгийн байдал ба уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг шударгаар бэлтгэн толилуулж байна гэдгийг үүгээр батлан мэдэгдэж байна.

Б.Бат-Орших
Гүйцэтгэх захирал

Ерөнхий нягтлан бодогч

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2025 оныдугаар сарын ...

АГУУЛГА

ХУУДАС

Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл.....	1
Компанийн талаарх мэдээлэл.....	3
Хараат бус аудиторын тайлан.....	4-6
Санхүүгийн байдлын тайлан.....	7
Ашиг, алдагдал, орлогын тайлан.....	8
Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
Мөнгөн гүйлгээний тайлан	10
Тайлагнагчийн мэдээлэл.....	11-12
СТОУС-д орсон өөрчлөлтүүд.....	12
Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй.....	13-22
Санхүүгийн тайлангийн тодруулгууд.....	20-27
Гэрээт ажлын захидал.....	28-29

“АКСИС КАПИТАЛ ББСБ” ХХК-ийн товч мэдээлэл:

Албан ёсны хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Их наяд зүүн өндөр, 1111 тоот давхарт,
Салбар нэгж:	-УБ хот, 8-р хороо, Соёмбо төв, 4д-402 тоотод -УБ хот, Чингэлтэй дүүрэг 5-р хороо, Нисдэг машин төв 4 давхарт 412 тоотод тус тус байрладаг.
Хувьцаа эзэмшигч:	Х.Бүрэн-Эрдэнэ Б.Бат-Орших Б.Мөнх-Орших
Гүйцэтгэх захирал:	Б.Бат-Орших
Харилцагч банкууд:	Худалдаа хөгжлийн банк Хаан банк
Аудитын компани:	“Сэрэлт Дөл Аудит” ХХК
Үйл ажиллагааны зөвшөөрөл:	Аудит баталгаажуулалтын үйл ажиллагааны 23-2015 дугаарын тусгай зөвшөөрөлтэй
Албан ёсны хаяг:	УБ хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Сүхбаатарын гудамж, Peace building . 302 тоот



“АКСИС КАПИТАЛ ББСБ” ХХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;
Цахим шуудан: altantsetseg@sdaudit.mn

2025. 01. 31 № СТА/25-09
танай _____ -ны № _____ -т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “Аксис Капитал ББСБ” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (цаашид “СТОУС” гэх)-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт тусгасан.

Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “НББЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа мөрдөж ажилласан болно. Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Санхүүгийн тайланд Удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээдэг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа, санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулахын тулд дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн удирдлага санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд, тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу тайлангууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нэгдсэн дүнгээрээ уг санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

“АОУС”-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилласан.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн “Аксис Капитал ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчид зориулан бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2025 оны 01 сарын 31



Д.АЛТАНЦЭЦЭГ
Захирал, ММНБ

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

			/ төгрөгөөр/
Үзүүлэлт	Тод	2023.12.31	Аудитлагдсан 2024.12.31
Хөрөнгө			
Мөнгөн хөрөнгө	3		764,171,928.14
Зээл /Цэврээр/	4		17,610,734,020.12
Бусад санхүүгийн хөрөнгө	5		10,267,800.00
<u>Санхүүгийн хөрөнгийн дүн</u>			<u>18,385,173,748.26</u>
Үндсэн хөрөнгө	6		184,061,489.49
Биет бус хөрөнгө	7		22,958,156.80
Бусад санхүүгийн бус хөрөнгө	8		-
<u>Санхүүгийн бус хөрөнгийн дүн</u>			<u>207,019,646.29</u>
<u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</u>			<u>18,592,193,394.55</u>
Өр төлбөр			
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	9		
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	10	-	6,500,000,000.00
Бусад эх үүсвэр	11		56,219,178.11
Бусад санхүүгийн өр төлбөр	12		
<u>Санхүүгийн өр төлбөрийн дүн</u>		=	<u>6,556,219,178.11</u>
Татвар,НДШ-ийн өр төлбөр	13	-	211,246,011.28
Бусад санхүүгийн бус өр төлбөр	14		-
<u>Санхүүгийн бус өр төлбөрийн дүн</u>			<u>211,246,011.28</u>
<u>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</u>		=	<u>6,767,465,189.39</u>
Өмч			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	15	-	10,000,000,000.00
Хуримтлагдсан ашиг		-	1,824,728,205.16
<u>НИЙТ ӨМЧИЙН ДҮН</u>		-	<u>11,824,728,205.16</u>
<u>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</u>		=	<u>18,592,193,394.55</u>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тодруулга	2023.12.31	2024.12.31
ХҮҮГИЙН ОРЛОГО			
Банканд байршуулсан хөрөнгийн	16		18,389,682.13
Зээлийн	16		2,602,410,489.31
Бусад	16		-
Хүүгийн орлогын буцаалт			-
Хүүгийн орлогын дүн			2,620,800,171.44
Хүүгийн зардал			405,712,329.07
Итгэлцлийн үр шим	17		
Зээлийн	17		
Үнэт цаасны	17		
Бусад			
Хүүгийн зардлын дүн			405,712,329.07
Хүүгийн цэвэр орлого			2,215,087,842.37
Эрсдэлийн сангийн зардал	18		-
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого			2,215,087,842.37
Бусад орлого	19		185,665,210.81
Бусад зардал	20		370,859,445.44
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ, АЛДАГДАЛ			2,029,893,607.74
Орлогын татварын зардал	21		205,165,402.57
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ, АЛДАГДАЛ			1,824,728,205.17
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ, АЛДАГДАЛ			1,824,728,205.17

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/мөгрөгөөр/

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан Ашиг/алдагдал/	Нийт дүн
2022 оны 12 сарын 31-ний				
үлдэгдэл				
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл				
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				
Хуваарилсан ногдол ашиг				
Өмчид гарсан өөрчлөлт				
2023 оны 12 сарын 31-ний				
үлдэгдэл				
Залруулсан үлдэгдэл				
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			1,824,728,205.16	1,824,728,205.16
Хуваарилсан ногдол ашиг				
Өмчид гарсан өөрчлөлт				
2024 оны 12сарын 31-ний				
үлдэгдэл				
	10,000,000,000.00		1,824,728,205.16	11,824,728,205.16

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2023.12.31	2024.12.31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан		2,272,473,035.21
Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан		-
Бусад		13,573,622,422.25
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого		<u>15,846,095,457.46</u>
Олгосон зээл		-
Буцаан олгосон итгэлцэл, үр шим		-
Ажиллагсдад олгосон		143,813,477.61
Татвар,НДШ-ийн байгууллагад төлсөн		51,510,527.88
Ашиглалтын зардалд төлсөн		962,120.00
Бусад		24,885,637,403.83
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага		<u>25,081,923,529.32</u>
<u>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</u>		<u>-9,235,828,071.86</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Хөрөнгө оруулалтаас хүлээн авсан		10,000,000,000.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн		<u>10,000,000,000.00</u>
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төл		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага		
<u>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</u>		<u>10,000,000,000.00</u>
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлээс хүлээн авсан		
Бусад		
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого		
Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлд төлсөн		
Бусад		
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага		
<u>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</u>		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		<u>764,171,928.14</u>
<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</u>		<u>00,0</u>
<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u>		<u>764,171,928.14</u>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

1. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖИЙН МЭДЭЭЛЭЛ

“Аксис Капитал ББСБ” ХХК (цаашид “Компани” гэх) нь 2023 оны 11 сарын 10-нд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үүсгэн байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. **Үйл ажиллагааны чиглэл:** Монгол улсын нутаг дэвсгэрт зээлийн үйл ажиллагаа, үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг.

Монгол Улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрхзүйн байдлын тухай” хууль болон бусад хуультогтоомжийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн ТЗ101/752 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, түүний хавсралтаар “зээл олгох” үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан. СЗХорооны 2024 оны 03 сарын 20 ний өдрийн 97 тоот тушаалаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 10,000,000,000 байна.

Компанийн албан ёсны хаяг нь: Монгол улс, УБ хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Их Монгол улсын гудамж 04, Их Наяд Зүүн өндөр 1111 тоот байранд гэсэн албан ёсны хаяг дээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Улсын бүртгэлийн дугаар:

9015005175

Регистрийн дугаар

8439699

Өмчийн хэлбэр: Компани нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг 3 гишүүнтэй байгууллага. Дүрмийн сан нь Хувьцаа эзэмшигдээс оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд нийт дүн нь 10,000,000,000 төгрөг ба нэг бүр нь 1,000,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,000 ширхэг энгийн хувьцаатай байна.

Хувьцаа эзэмшигчийн нэр	Эзэмшлийн хувь
Х.Бүрэн-Эрдэнэ	75%
Б.Бат-Орших	25%
Б.Мөнх-Орших	5%

Тайланг хамарсан хугацаа: 2024 оны 1 дүгээр сарын 1-нээс 2024 оны 12 дугаар сарын 31

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ

2.1 Тайланг бэлтгэх үндэслэл

Компанийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НББОУСЗ”)–өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын (“СТОУС”)–ын дагуу бэлтгэж, Санхүүгийн Зохицуулах Хорооны удирдамж (“СЗХ-ны удирдамж”)–ийн дагуу бэлтгэгдсэн.

Тайлангийн мөнгөн тэмдэгт

Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэх үзүүлэлтийн нэгж нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг, мөнгөөр илэрхийлсэн байна. Компанийн санхүүгийн тайлангуудыг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Тасралтгүй байх зарчим

2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Компанийн цэвэр эргэлтийн хөрөнгө нь 11,885,173.7 мянган төгрөг (2023: 00,0 мянган төгрөг) байгаа нь Компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадвартай байгааг харуулж байна.

2.2 ШИНЭ БОЛОН ӨӨРЧЛӨЛТ ОРСОН СТАНДАРТУУД

2024 оны 1 сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа доорх стандарт болон стандартын нэмэлт өөрчлөлтүүдээс бусад тохиолдолд өмнөх санхүүгийн жилд мөрдөж байсан бүртгэлийн бодлогуудаа энэ санхүүгийн жилд тууштай мөрдөж байгаа болно.

Хэрэгжих хугацаа	Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд
2024.01.01	СТОУС-16 Түрээс Борлуулах ба буцаан түрээслэхтэй холбоотой хувьсах төлбөрийн өөрчлөлт
2024.01.01	НББОУС-1 Санхүүгийн тайлангийн тодруулга Эргэлтийн ба эргэлтийн бус өр төлбөрийн ангилал, эргэлтийн бус өр төлбөрийн гэрээгээр хүлээх үүрэг хариуцлагын талаарх өөрчлөлт
2024.01.01	НББОУС-7 Мөнгөн гүйлгээний тайлан, СТОУС-7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга Нийлүүлэгчийн санхүүжилтийн зохицуулалтын нэмэлт өөрчлөлтүүд
2024.01.01	СТОУС-ТБ1 Тогтвортой байдалд хамаарах санхүүгийн мэдээллийг тодруулах ерөнхий шаардлага
2024.01.01	НББОУС-21 Гадаад валютын ханшийн үр нөлөө Арилжааны алдагдлын талаарх нэмэлт өөрчлөлт

Дээрх шинэ стандарт болон стандартуудын нэмэлт өөрчлөлт нь Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлээгүй.

2.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо

а. Эргэлтийн болон эргэлтийн бус ангилал

Компани хөрөнгө болон өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайланд эргэлтийн болон эргэлтийн бус ангиллын дагуу толилуулна. Дараах тохиолдолд хөрөнгө эргэлтийн хөрөнгө болно.

- Хэвийн үйл ажиллагааны явцад хэрэгжих болон борлуулах хандлагатай эсвэл хэрэглэхээр хүлээгдэж байгаа
- Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж байгаа
- Тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор хэрэгжихээр хүлээгдэж байгаа эсвэл
- Тайлант хугацаанаас хойш хамгийн багадаа 12 сарын дотор солилцох эсвэл өр төлбөр барагдуулахыг хязгаарлаагүй бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

2.3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо(үргэлжлэл)

Бусад бүх хөрөнгө нь эргэлтийн бус хөрөнгө болно.

Өр төлбөр нь дараах тохиолдлуудад богино хугацаат өр төлбөр болно.

- Хэвийн үйл ажиллагааны явцад төлөгдөхөөр хүлээгдэж буй
- Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж байгаа
- Тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор төлөх хугацаатай, эсвэл
- Тайлант хугацаанаас хойш хамгийн багадаа 12 сар өр төлбөр барагдуулалтыг хойшлуулах нөхцөлгүй

Компани бусад бүх өр төлбөрүүдийг эргэлтийн бус гэж ангилдаг.

b. Гадаад валютын хөрвүүлэлт

Үйл ажиллагааны болон толилуулгын валют

Монгол улсын мөнгөн тэмдэгт Төгрөг нь Компанийн үндсэн үйл ажиллагаа болон ажил гүйлгээний эдийн засгийн бодит байдлыг хамгийн тохиромжтой илэрхийлж байгаа учраас төгрөг нь уг Компанийн үйл ажиллагааны валют юм. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө, төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар дахин хөрвүүлдэг, Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөр төлөгдөх эсвэл хөрвүүлэх үед үүссэн бүх зөрүү нь ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдана. Түүхэн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг анхны гүйлгээ хийсэн өдрийн ханшаар бүртгэнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ.

Мөнгөн бус мэдээллийн өөрчлөлттэй холбоотой ашиг, алдагдал боломжийн үнийн өөрчлөлтийн ашг, алдагдалтай харьцуулна.

Төгрөгийн нэгж ам доллортой харьцах ханш 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1 ам доллор = 3,420.46 төгрөг (2023: 1 ам доллор=3,410.69).

c. Хүү болон түүнтэй адилтгах орлого ба зардал

Хүү бүхий санхүүгийн хэрэглүүрүүдийн хүүгийн орлого, зардлыг холбогдох санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн үр ашигт хүүгийн хувийг хэрэглэн орлогын тайланд “Хүү болон түүнтэй адилтгах орлого” ба “Хүү болон түүнтэй адилтгах зардал” гэж хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон зээл, урьдчилгааны хүүгийн орлогоос бусад хүүгийн орлогыг аккрузл сууриар дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлогыг анхны үр ашигт хүүгийн хувь хэмжээгээр тооцож хүлээн зөвшөөрнө.

d. Хураамж ба шимтгэлийн орлого

ББСБ-ын хураамж, шимтгэлийн орлого нь ихэвчлэн зээлийн өргөдөл, гүйлгээний болон бусад төрлийн хураамж, гэрээний бүтцэд өөрчлөлт оруулсны шимтгэл, урьдчилсан төлөлтийн шимтгэл зэргээс бүрддэг. Хураамж, шимтгэлийн орлогыг үйлчилгээ үзүүлсэн хугацаанд нь аккрузл сууриар хүлээн зөвшөөрдөг.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

2.3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо(үргэлжлэл)

е. Зээлийн зардал

Хөрөнгийн худалдан авалт, бүтээн байгуулалт эсвэл төлөвлөсөн зориулалт эсвэл борлуулахад бэлэн болгоход ихээхэн хэмжээний цаг хугацаа шаарддаг бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн зардлыг тухайн хөрөнгийн өртөгт капиталжуулдаг.

ф. Ажиллагсдын тэтгэмж

Богино хугацааны тэтгэмж

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Компанийн ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Монгол улсын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа Компаниуд нь Монгол улсын Эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь ашиг, алдагдалд зардлаар хүлээн зөвшөөрнө.

г. Татвар

Тайлант хугацааны орлогын албан татвар

Компани нь Монгол Улсын Засгийн газрын дүрэм журмын дагуу татвар ногдох орлогыг нэмэгдүүлэхгүй орлого болон татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын зүйлсээр залруулсан, санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлсон өөрийн орлогоос тайлан тэнцлийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээгээр бодож өөрийн орлогын албан татварын хэмжээг тодорхойлдог. Тайлант хугацааны болон өмнөх тайлант жилүүдийн орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас авахаар эсвэл тэдгээрт төлөхөөр хүлээж буй дүнгээр хэмжсэн.

Тайлант хугацааны татварын хөрөнгө болон өр төлбөрийг хуулийн дагуу цэвэршүүлэх эрхтэй, мөн Компани цэвэршүүлсэн дүнгээр төлөх буюу буцаан авахаар төлөвлөж байгаа буюу татварын хөрөнгө болон өр төлбөрийг нэгэн зэрэг буцаан авах ба төлөх тохиолдолд цэвэршүүлэн тайлагнана. Өөрийн хөрөнгөд шууд хүлээн зөвшөөрөгдөх зүйлсэд ногдох орлогын албан татвар нь ашиг, алдагдал биш өөрийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөгдөнө.

Удирдлага нь нягтлан бодох бүртгэлийг яаж хөтлөхийг холбогдох татварын хууль журмуудад тодорхой зааж өгөөгүй, нэмэлт тайлбар тодруулга шаардлагатай шинэ нөхцөл байдал үүссэн эсэхийг тодруулахаар тодорхой хугацаа тутамд татварын тайлангаа хянаж үздэг ба шаардлагатай бол сан байгуулдаг.

2. **Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)**

2.3. **Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо(үргэлжлэл)**

Хойшлуулсан албан татвар

Санхүүгийн байдлын тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татвар ногдох дүн ба тэдгээрийн санхүүгийн тайлан дээрх бүртгэлийн хооронд гарах түр зөрүүнд "Өр төлбөрийн арга"-ыг ашиглан хойшлогдсон орлогын албан татварыг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын өр төлбөр нь түр зөрүүнд хүлээнд зөвшөөрөгдөнө. Хойшлогдсон албан татварын хөрөнгийг татвар ногдох орлогоос хасагдах бүх түр зөрүүнүүд, ирээдүйд шилжүүлэн тооцох, ашиглаагүй татварын бүх хөнгөлөлт ба алдагдлуудад (эдгээр түр зөрүү, хөнгөлөлт, алдагдлуудыг хасаж болох татвар ногдох орлогын ирээдүйд орж ирэх нь тодорхой болсон үед) хүлээн зөвшөөрнө.

h. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тооцож тусгана. Үндсэн хөрөнгийн анхны өртөгт худалдан авсан үнэ, импортын татвар, татварууд болон хөрөнгийг ашиглалтанд оруулахтай холбогдон гарсан шууд зардлууд орно.

Үндсэн хөрөнгө анх үнэлж байсан стандарт гүйцэтгэлээс илүү гарч түүнийг ашиглахтай холбогдон гарсан зардал ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг өсгөсөн нь тодорхой болсон бол зардлыг үндсэн хөрөнгийн нэмэлт өртгөөр капиталжуулна.

Хөрөнгийг борлуулах болон данснаас хасах үед тухайн хөрөнгийн өртөг, хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын дүнг оролцуулан данснаас хасах бөгөөд үүнээс үүсэх аливаа олз, гарзыг тайлант жилийн орлого, үр дүнгийн тохирох хэсэгт бүртгэнэ.

Барилга байгууламж, газрын тохижилт	40	25
Машин, механизм, техник, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж	10	
Компьютер, дагалдах тоног төхөөрөмж, программ хангамж	2	
Ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө /Үүнд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хамаарна./	Хүчин төгөлдөр байх хугацаанд	
Бусад хөрөнгө	10	

j. Биет бус хөрөнгө

Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт (ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцно.) болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

2.3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо(үргэлжлэл)

j. Биет бус хөрөнгө(үргэлжлэл)

Биет бус хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз, гарз нь цэвэр борлуулалтын орлого болон хөрөнгийн бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр хэмжигдэж ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрөгдөнө.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой болон тодорхой бус гэж хоёр ангилна. Компанийн биет бус хөрөнгө нь газар эзэмших эрх болон компьютерийн программаас бүрдэх бөгөөд ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгийн ангилалд багтана. Эдгээр хөрөнгө нь тооцоолсон ашиглалтын хугацаа болон (3) арван (60) жилийн хугацаанд шулуун шугамын аргыг ашиглан хорогдуулна.

k. Санхүүгийн хэрэгсэл

1) Санхүүгийн хэрэгслийн анхны хүлээн зөвшөөрөлт

Анх хүлээн зөвшөөрч буй санхүүгийн хэрэгслийн ангилал нь тэдгээрийн зориулалт, шинж чанараас шалтгаална. Санхүүгийн хэрэгслүүдийг анхлан бодит үнээр нь хэмжих ба харин бодит үнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар тайлагнагдахгүй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хувьд бодит үнэ дээр тэдгээртэй шууд холбоотой худалдан авалтын эсвэл гаргалтын ахиуц зардлуудыг нэмсэн дүнгээр бүртгэнэ.

2) Санхүүгийн хэрэгслийн ангилал

Арилжаалах зорилгоор эзэмшиж буй хэрэгслүүд нь ерөнхийдөө ашиг олох зорилгоор богино хугацаанд ББСБ-ын эзэмшиж буй зүйлс юм. Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрүүдийг тайлан тэнцэлд бодит үнээр нь бүртгэнэ. “Арилжааны цэвэр орлого”-д бодит үнийн өөрчлөлтийг тусгана. Хүүгийн орлого эсвэл зардлыг гэрээний нөхцөлийн дагуу эсвэл төлбөрийн эрх үүссэн үед “Цэвэр арилжааны орлого”-д бүртгэнэ. Энэ ангилалд өрийн үнэт цаас, энгийн хувьцаа, ойрын хугацаанд буцаан худалдан авах эсвэл худалдах зорилгоор эзэмшиж байгаа үнэт цааснууд багтана.

Харилцагчдад олгосон зээл нь ББСБ-аас зээлдэгчдэд мөнгө олгох замаар бий болгосон зээл, авлага юм. Энэхүү олгосон зээл ба авлага нь идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлох боломжтой төлбөрүүдтэй, тогтсон дуусгавар хугацаатай санхүүгийн хэрэгслүүд юм. Анхны хэмжилтийн дараа харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн хорогдуулсан өртгөөс үнэ цэнэ бууралтын санг хассан дүнгээр бүртгэнэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцно.

Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хэрэгсэл нь ББСБ дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших боломжтой, тогтмол буюу тодорхойлогдохуйц төлбөртэй санхүүгийн хөрөнгүүд юм. ББСБ нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших хандлага ба чадвартай, тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөртэй ба тогтоосон хугацаатай санхүүгийн хэрэглүүрүүдийг дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт гэнэ. Анхны хэмжилтийн дараа, дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

2.3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо(үргэлжлэл)

к. Санхүүгийн хэрэгсэл(үргэлжлэл)

оруулалтыг үр ашигт хүүгийн арга ашиглаж тооцсон хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмжинэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцдог. Хорогдуулалт нь ашиг алдагдлын тайлангийн “Хүү болон түүнтэй адилтгах орлого”-д орно. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлого, үр дүнгийн тайлангийн “Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдал” хэсэгт хүлээн зөвшөөрнө.

Борлуулах боломжтой санхүүгийн хэрэгсэл гэдэг нь тус ББСБ-аас гаргасан арилжааны зориулалтаар эзэмшээгүй буюу дуусгавар хугацаа хүртэл нь эзэмшихгүй санхүүгийн хөрөнгүүд юм. Эдгээрт өөрийн хөрөнгийн хэрэглүүр, хамтын санд оруулсан хөрөнгө оруулалтууд, мөнгөний зах зээлийн ба бусад өрийн хэрэглүүрүүд багтдаг.

Анх хүлээн зөвшөөрсний дараа борлуулах боломжтой хөрөнгө оруулалтыг бодит үнээр нь хэмждэг. Бодит бус ашиг алдагдлыг өөрийн хөрөнгийн “Борлуулахад бэлэн сан”-д шууд хүлээн зөвшөөрдөг.

Өрийн бичиг ба зээлээр авсан эх үүсвэр нь тус ББСБ-ын бусад банк, санхүүгийн байгууллагуудаас төвлөрүүлсэн гэрээт эх үүсвэрийг илэрхийлнэ. Өрийн бичиг ба зээлийн эх үүсвэрийг анх өртгөөр хүлээн зөвшөөрнө.

Анх хүлээн зөвшөөрсний дараа, зээлээр авсан санхүүжилт дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо зээл авах үеийн хөнгөлөлт, урамшуулал ба үр ашигт хүүгийн нэг салшгүй хэсэг болж буй зардлуудыг авч үзнэ.

Арилжааны бус санхүүгийн өр төлбөр

Арилжааны бус санхүүгийн өр төлбөр гэдэгт харилцагчид болон бусад санхүүгийн байгууллагаас авсан хүү бүхий зээллэг болон бусад өглөгүүд орно. Арилжааны бус өр төлбөрийг анх өртгөөр нь тусгадаг. Анхдагч хүлээн зөвшөөрөлтөөс хойш тэдгээр нь хорогдуулсан өртөг буюу өртөг болон үлдэх өртгийн хоорондын зөрүүгийн хамт тусгагдан, үр ашигт хүүгийн аргаар тухайн хэрэгслийн хугацааны турш орлогын тайланд хүлээн зөвшөөрөгддөг.

1. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгө нь гар дээрх бэлэн мөнгө, арилжааны банкин дахь харилцах данснаас бүрдэж байна.

Зээл ба урьдчилгаа

Тус ББСБ-ын харилцагчдад олгосон зээл нь зээл ба авлагаар ангилагдсан. Эргэн төлөгдөхөөр тооцоолсон дүнг тусгах зорилгоор зээлийн эрсдэлийн санг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

2.3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо(үргэлжлэл)

м. Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Үнэ цэнийн бууралтын аливаа нэг шинж тэмдэг илрэх үед болон хөрөнгийн (бараа материал болон санхүүгийн хөрөнгөөс бусад) бүртгэлийн дүнгүүд үнэ цэнийн бууралтад орсон эсэхийг тооцоолж үзнэ. Хэрэв үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн тооцоолсон нөхөн төлөгдөх дүнг боддог.

Хөрөнгийн нөхөгдөх дүн нь хөрөнгийн бодит үнээс борлуулалтын зардлыг хассан дүн ба түүний бүртгэлийн дүн хоёрын аль өндөр нь байх бөгөөд хөрөнгө нь бусад хөрөнгийн эсвэл бүлэг хөрөнгөөс хамааралгүйгээр мөнгөн урсгалыг бий болгохгүй байвал хөрөнгө нэг бүрийн нөхөгдөх дүнг тодорхойлно.

Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг зөвхөн хөрөнгийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс хэтэрсэн тохиолдолд хүлээн зөвшөөрнө. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөнд харгалзах эрсдэлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно.

Хэрвээ чаддаггүй бол хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтын зорилгоор бэлэн мөнгө бий болгогч нэгжүүдэд ангилагдана.

Эдгээр мөнгө бий болгогч нэгжүүд нь бусад хөрөнгө болон бүлэг хөрөнгийн бэлэн мөнгөний урсгалаас ихээхэн хамааралгүй салангид тодорхойлогдох боломжтой бэлэн мөнгөний орох урсгалуудын хамгийн бага түвшинг илэрхийлнэ. Энэ нь ихэвчлэн Компанийг санхүүгийн бус хөрөнгүүдээ газар зүйн болон лицензээр нь үнэлгээ хийхэд хүргэдэг. Хэрэв санхүүгийн бус хөрөнгийн бүртгэлийн дүн нь нөхөн төлөгдөх дүнгээсээ хэтэрсэн бол хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн нөхөн төлөгдөх дүн хүртэл нь бууруулж, зөрүүг (хөрөнгийн бодит үнээс борлуулалтын зардлыг хассан дүн ба түүний ашиглалтын дүн хоёрын аль өндөр нь байна ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд “Үнэ цэнийн бууралт”-аар хүлээн зөвшөөрнө.

п. Санхүүгийн хөрөнгө

Анхлан хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Анхлан хүлээн зөвшөөрөлтийн үед санхүүгийн хөрөнгийн ангилал нь тухайн гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанар ба Компанийн хөрөнгийг удирдах бизнесийн загвараас хамаарна. Компани нь санхүүгийн томоохон бүрэлдэхүүн хэсэг агуулаагүй худалдааны авлагаас бусад санхүүгийн хөрөнгийг анхлан бодит үнэ цэнээр нь хэмжиж, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар илэрхийлэгдэх хөрөнгөөс бусад хөрөнгийн бодит үнэ дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр хэмжинэ.

Компани санхүүгийн хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө Компанийн хөрөнгө удирдах бизнесийн загварт үндэслэн дараах ангиллуудад хуваарилна:

- Хорогдуулсан өртгөөр
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод (“БҮЦӨБДО”) илэрхийлэгдэх
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар (“БҮЦӨАА”) илэрхийлэгдэх

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

2.3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо(үргэлжлэл)

о. Санхүүгийн өр төлбөр

Анх хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Санхүүгийн өр төлбөрийг аль зохистой ангилалд нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх, зээл ба зээллэг, эсвэл үр нөлөөтэй хейджингийн хэрэглүүрээр анх хүлээн зөвшөөрнө.

Бүх санхүүгийн өр төлбөрүүдийг анх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба зээл, зээллэг болон өр төлбөрийн хувьд шууд хамааралтай гүйлгээний зардлыг хассаны дараах дүнгээр хүлээн зөвшөөрнө. Компанийн санхүүгийн өр төлбөрүүдэд зээллэг, хойшлогдсон орлогын өр төлбөр, хүүгийн өглөг, дансны болон бусад өр төлбөр орно. Бүх санхүүгийн өр төлбөрүүд нь зээллэг ба хойшлогдсон орлогын өр төлбөр гэж ангилагдсан.

Дараах үеийн хэмжилт

Санхүүгийн өр төлбөрийн дараах үеийн хэмжилт нь доор дурдсан ангиллаас шалтгаална:

Зээл ба зээллэг

Анх хэмжсэний дараа, зээл ба зээллэгийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх үед болон үр ашигт хүүг ашиглан хорогдуулах үеийн олз, гарзыг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний салшгүй хэсэг болох зээл олголтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэл, холбоотой зардлуудыг оролцуулан тооцдог. Үр ашигт хүүгийн хорогдуулалт нь дэлгэрэнгүй орлогын тайлангийн санхүүгийн зардалд багтана.

Үл хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзэх ба бүртгэлийн дүнгийн зөрүүг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

р. Санхүүгийн хэрэглүүрүүдийн цэвэршүүлэх

Хэрэв байгууллага хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр тайлан тэнцэлд толилуулах эрхтэй

қ. Санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ

Хэмжилтийн өдөр зах зээлийн оролцогчдын хооронд зохих журмын дагуу хийгдэж буй гүйлгээний үед хөрөнгө борлуулахад хүлээн авч буй эсвэл өр төлбөрийг шилжүүлэхэд төлж буй үнийг бодит үнэ цэнэ гэнэ.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

2.3. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо(үргэлжлэл)

q. Санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ (үргэлжлэл)

Бодит үнэ цэнийн хэмжилт нь дараах тохиолдлуудад болж буй хөрөнгийг борлуулах болон өр төлбөрийг шилжүүлэх гүйлгээний таамаглалд үндэслэдэг.

Үүнд:

- Хөрөнгө, өр төлбөрийн үндсэн зах зээлд эсвэл
- Үндсэн зах зээл байхгүй үед хөрөнгө, өр төлбөрийн хамгийн давуу зах зээлд

Компани үндсэн болон давуу зах зээлд оролцох боломжтой байх ёстой.

Зах зээлийн оролцогчид нь хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоох үед өөртөө эдийн засгийн хувьд хамгийн ашигтай байхаар оролцоно гэсэн төсөөллийг ашиглан хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжинэ.

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтэд хөрөнгийг хамгийн үр ашигтайгаар ашиглаж эсвэл хөрөнгийг хамгийн үр ашигтайгаар ашиглах зах зээлийн өөр нэг оролцогчид хөрөнгийг борлуулснаар эдийн засгийн өгөөжийг бий болгох зах зээлийн оролцогчийн чадварыг харгалзаж үзнэ.

Санхүүгийн тайланд хэмжиж, тодруулсан бүх хөрөнгө болон өр төлбөрүүдийг бодит үнэ цэнийн түвшинд дараах байдлаар ангилсан ба ангилахдаа бодит үнэ цэнийн хэмжүүрт бүхлээрээ томоохон нөлөөтэй хамгийн бага түвшний орцод үндэслэсэн:

- Түвшин 1 - хөрөнгө, өр төлбөрийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй (залруулаагүй), идэвхтэй зах зээл дээрх үнэ,
- Түвшин 2 - шууд болон шууд бусаар ажиглах боломжтой хамгийн бага түвшний орцууд нь бодит үнэ цэнэд томоохон нөлөө үзүүлэх үнэлгээний техникүүд
- Түвшин 3 - ажиглах боломжгүй хамгийн бага түвшний орц нь бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон нөлөөтэй үнэлгээний техникүүд

г. Нөөцүүд

ББСБ –нь өмнөх үеийн үйл явдлын үр дүнд хууль ёсны хариуцлага хүлээж буй болон эдийн засгийн үр өгөөжийн гаргах урсгалд хариуцлага биелүүлэх шаардлагатай болсон үед балансад нөөцийг хүлээн зөвшөөрдөг. Зээл төлөгдөхөд учирч болзошгүй эрсдлээс хамгаалах нөөц болон өмчлөх бусад хөрөнгийн борлогдохгүй байх эрсдэлийн түвшин нь он тус бүрийн хувьд дараахь байдалтай байсан:

	2023 он	2024 он
Хэвийн	0%	0%
Хугацаа хэтэрсэн	5%	5%
Хэвийн бус	25%	25%
Эргэлзээтэй	50%	50%
Муу	100%	100%

- Зээл, өмчлөх бусад хөрөнгөөс бусад хөрөнгийн хувьд, түүний эргэн төлөгдөх магадлалын талаарх удирдлагын үнэлгээнд суурилан зөвхөн тусгай нөөцүүдийг байгуулдаг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Касс дахь мөнгө	-	886,972.86
Банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө		763,284,955.28
Нийт дүн		764,171,928.14

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь Хаанбанк, Худалдаа хөгжлийн банкуудад байршуулсан харилцах болон хадгаламжийн дансуудаас бүрдэж байна.

4. Зээл

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Хэвийн зээл		17,334,913,363.67
Анхаарал хандуулсан зээл		-
Чанаргүй зээл		-
-Хэвийн бус		-
-Эргэлзээтэй		-
-Муу		-
Зээлийн эрсдлийн сан		-
Зээл хуримтлуулж тооцсон хүүгийн авлага		275,820,656.45
Нийт зээл		17,610,734,020.12

Компанийн зээл авсан зээлдэгчид нь богино хугацаанд санхүүгийн хэрэглээгээ санхүүжүүлэх зорилготой хүмүүс байдаг. Тайлант онуудад иргэдэд 17,905,661,089.97 төгрөгийн зээл олгосноос 1,900,295,700.40 төгрөгийн зээл төлөгдөж, 16,005,365,389.97 төгрөгийн зээл үлдсэн байна. Мөн Хуулийн этгээдэд 4,089,999,998.40 төгрөгийн зээл олгосноос 2,760,452,024.30 төгрөгийн зээл төлөгдөж, 1,329,547,974.10 төгрөгийн зээл үлдсэн байна.

Зээлийг ангилалаар нь үзвэл:

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Хэрэглээнд зориулсан зээл		495,249,783.53
Автомашин худалдан авахад зориулсан зээл		15,510,115,606.04
Бизнесийн зээл		1,329,547,974.10
Нийт зээл		17,334,913,363.67

Үүнээс бизнесийн зээлийн үлдэгдэл 1,329,547,974.10 төгрөг нь 3 хуулийн этгээдтэй холбоотой үлдэгдэл байна.

5. Бусад авлага

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
----------	------------	------------

Нийт дүн

6. Үндсэн хөрөнгө ба элэгдэл

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тавилга эд хогшил	Компьютер дагалдах хэрэгсэл	Тээврийн хэрэгсэл	Нийт дүн
<u>Үндсэн хөрөнгө</u>				
Эхний үлдэгдэл	0.00	0.00		0.00
Нэмэгдсэн	73,323,710.00	121,476,005.00		194,799,715.00
Худалдан авсан				
Үнэ төлбөргүй авсан				
Хасагдсан				
Худалдсан				
Акталсан				
Үнэгүй шилжүүлсэн				
Эцсийн үлдэгдэл	73,323,710.00	121,476,005.00		194,799,715.00
<u>Хуримтлагдсан элэгдэл</u>				
Эхний үлдэгдэл	0.00	0.00		0.00
Тайлант жил байгуулсан	3,142,401.17	7,595,824.34		10,738,225.51
Хасагдсан				
Эцсийн үлдэгдэл	3,142,401.17	7,595,824.34		10,738,225.51
<u>Дансны үнэ</u>				
Эхний үлдэгдэл	0.00	0.00		0.00
Эцсийн үлдэгдэл	70,181,308.83	113,880,180.66		184,061,489.49

Тайлант онд 121,476,005.00 төгрөгийн техник хэрэгсэл, 73,323,710.00 төгрөгийн тавилга, эд хогшил худалдаж авсан ба тайланд онд 10,738,225.51 төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

7. Биет бус хөрөнгө

Үзүүлэлт	Программ хангамж	Бүгд дүн
<u>Эхний үлдэгдэл</u>		
Нэмэгдсэн	00.00	0.00
Хасагдсан	24,049,525.00	24,049,525.00
Хасагдсан	1,091,368.20	1,091,368.20
Эцсийн үлдэгдэл	22,958,156.80	22,958,156.80
Хуримтлагдсан хорогдол		

8. Бусад санхүүгийн бус хөрөнгө

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Урьдчилж төлсөн тооцоо/зардал	0.00	10,267,800.00
<u>Нийт дүн</u>	<u>0.00</u>	<u>10,267,800.00</u>

9. Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
1 жил хүртлэх хугацаатай 1-ээс дээш жилийн хугацаатай Итгэлцлээр татсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон үр шим		
<u>Нийт дүн</u>		

10. Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Төлөгдөх хугацаандаа байгаа зээл		6,500,000,000.00
Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг		56,219,178.11
<u>Нийт дүн</u>		<u>6,556,219,178.11</u>

11. Бусад эх үүсвэр

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Гаргасан өрийн бичиг Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг		
<u>Нийт дүн</u>		

12. Бусад санхүүгийн өр төлбөр

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Бусад		
Нийт дүн		

13. Татвар, НДШ-ийн өр төлбөр

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
НДШ-ийн өглөг		
ХХОАТ өглөг		
ХХОАТ суутган өглөг		
Бусад татварын өглөг		7,916,476.25
ААНОАТ өглөг		203,326,434.35
Бусад		3,100.68
Нийт дүн		211,246,011.28

2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгээр 2,029,893,607.14 төгрөгийн татварын өмнөх ашигтай гарснаас үүдэн ААНБОАТ-ийн 203,326,434.35 төгрөгийн татварын өр үүссэн байна.

14. Бусад санхүүгийн бус өр төлбөр

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Бусад өглөг		
Бусад өглөг-депозит		
Нийт дүн		

15. Хувь нийлүүлсэн хөрөнгө

Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 11 сарын 15-ний 10 тоот шийдвэрээр 3 хувьцаа эзэмшигчтэйгээр дүрмийг өөрчлөн, 2024 оны 12 сарын 31-ний байдлаар “Аксис Капитал ББСБ” ХХК-ын дүрмийн сан нь 10,000,000,000 төгрөг бөгөөд 1,000,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 10,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна.

Энгийн хувьцаа	Хувьцааны тоо		Хувьцааны дүн	
	2023.12.31	2024.12.31	2023.12.31	2024.12.31
Зөвшөөрөгдсөн хувьцаа:	-	10,000	-	10,000,000,000
Дүн	=	10,000	=	10,000,000,000

16. Хүүгийн орлого

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Банканд байршуулсан хөрөнгийн		18,389,682.13
Зээлийн		2,602,410,489.31
Бусад		1,937,265.81
Хүүгийн орлогын буцаалт		-
<u>Нийт дүн</u>		<u>2,622,737,437.25</u>

2024 онд хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого 2,602,410,489.31 төгрөг, Харилцах дансны хүүгийн орлого 18,389,682.13 төгрөг, хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого 1,937,265.81 төгрөг байна.

17. Хүүгийн зардал

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Итгэлцлийн үр шим	-	
Зээлийн		405,712,329.07
Үнэт цаасны		-
Бусад		-
<u>Нийт дүн</u>		<u>405,712,329.07</u>

2024 онд Санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал 405,712,329.07 төгрөг байна.

18. Хүүгийн бус орлого

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого	-	183,727,945.00
Зээл хураамж шимтгэлийн орлого		
Бусад		
<u>Нийт дүн</u>		<u>183,727,945.00</u>

2024 онд Үйлчилгээний хураамж болон шимтгэлийн орлого 183,727,945.0 төгрөг байна.

19. Бусад зардал

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн гарз		
Банкны шимтгэлийн зардал		
Бусад үйлчилгээний зардал		11,538,208.00
Цалингийн зардал		180,197,005.80
Эрүүл мэнд, НДШ-ийн зардал		22,508,716.63
Зээл болон бусад авлагыг барагдуулахтай холбоотой зардал		255,000.00
Зарлал, сурталчилгаа, маркетингийн зардал		168,000.00
Элэгдэл, хорогдолын зардал		11,829,593.71
Даатгал		726,920.00
Түрээсийн зардал		58,000,100.00
Ашиглалтын зардал		962,120.00
Харилцаа холбооны зардал		5,309,103.67
Шатахууны зардал		2,206,231.00
Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ		7,360,840.00
Бичиг хэрэг		6,266,563.00
Үйл ажиллагааны бусад зардал		35,180,100.63
Нийт дүн		342,508,502.44

2024 ондоо Санхүүгийн бус зардал 342,508,502.44 төгрөг гарснаас гадна, үндсэн бус үйл ажиллагааны зардалд 28,350,943.00 төгрөгийн зардал гарсан байна.

20. Орлогын татварын зардал

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Тайлант хугацааны татварын зардал	-	205,165,402.57
Нийт дүн		205,165,402.57

2024 онд 2,029,893,607.74 төгрөгийн татварын өмнөх ашигтай гарснаас 205,165,402.57 төгрөгийн татварыг төсөвт төлөхөөр гарсан байна.

Компанийн орлогын албан татварын зардлыг санхүүгийн тайлангийн татварын өмнөх ашгийг орлогын татвар ногдохгүй орлого болон татвар ногдуулах орлогоос хасагдахгүй зардлаар тоируулга хийх замаар тооцон бүртгэдэг. Компани нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу 6 тэрбум хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар орлогын албан татвар төлдөг.

21. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төгрөг	Нийт дүн
Түргэн борлогдох актив	764,171,928.10	764,171,928.10
Касс дахь бэлэн мөнгө	886,972.90	886,972.90
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах	763,284,955.3	763,284,955.3
Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө	6,711,246,011.3	6,711,246,011.3
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	6,500,000,000.00	6,500,000,000.00
Санхүүгийн бус өр төлбөр	211,246,011.30	211,246,011.30
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа (8%-ээс дээш)	8%	8%
Харьцаа тайлангаар	11.4%	11.4%

Нийт дүн

22. Зээлийн эрсдлийн зардал

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
ЭХний үлдэгдэл		
Тайлант жилд нэмж байгуулсан		
Сангаас буцаасан		
Дүн		

Компани нь 2024 онд зээлийн эрсдлийн сан байгуулаагүй.

“ББСБ-нь зээлийн эрсдлийн зардлыг Санхүүгийн зохицуулах хорооны “банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах ,журам”-ын дагуу хувь хэмжээгээр байгуулж, зээлийн эрсдлийн санг тооцож, уг зөрүүгээр зээлийн эрсдлийн зардлыг тооцож бүртгэнэ гэж заагдсан байдаг.

23. Санхүүгийн эрсдлийн удирдлага

Удирдлага нь ББСБ-ын эрсдлийн удирдлагын бодлогод гол үүрэг хариуцлага хүлээхийн зэрэгцээ түүнийг тодорхойлж бэлтгэх үүрэгтэй байдаг. ББСБ-нь үйл ажиллагааны явцад дараах санхүүгийн эрсдэлүүдэд өртөх магадлалтай. Үүнд:

- ✓ Зээлийн эрсдэл
- ✓ Зах зээлийн эрсдэл
- ✓ Хөрвөх чадварын эрсдэл

23.1 Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл нь ББСБ-д санхүүгийн эрсдэл үүссэний улмаас гэрээний үүргээ гүйцэтгэж чадахгүй болох эрсдэлийг харуулдаг.

23.2 Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл нь тухайн байгууллагад учирч болох гадаад хүчин зүйл буюу банкны салбар, хөрөнгийн зах зээлийн үнийн хэлбэлзэл, гадаад валютын ханшийн өөрчлөлт, хууль зүй, татварын бодлого гэх мэт зах зээлийн орчноос хамаарч байгаа эрсдэл юм.

Хүүгийн түвшний эрсдэл гэдэг нь зах зээл дээрх зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл юм. ББСБ –нь зээлийн хүүг холбогдох журмын дагуу тогтоодог тул хүүгийн түвшний эрсдэлд өртөх магадлалтай.

24.Төлбөрийн чадварын эрсдэл

Төлбөрийн чадварын эрсдэл нь ажлын капитал, зээлийн хэрэглүүр дэх санхүүгийн төлбөр, үндсэн өрийг төлж барагдуулахтай холбоотой үүсдэг. Энэ нь ББСБ санхүүгийн өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулахад хүндрэлтэй тулгарах эрсдэл юм.

ББСБ-ын баримтлах бодлого бол үүргийн гүйцэтгэлийн хугацааны эцэст түүнийг барагдуулах хангалттай бэлэн мөнгөтэй байх явдал юм. ББСБ 2024 оны 12 сарын 31-нээр бусад санхүүгийн байгууллага, хувь хүмүүсээс авсан зээлгүй тул төлбөрийн чадварын эрсдэлд өртөх магадлал бага байна.

25. Балансын дараах үйл явдал

2025 оны 01 сарын 01-нээс 2025 оны 03 сарын 15 өдөр хүртэл “Аксис Капитал ББСБ”-ийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөхүйц, тодруулахыг шаарддаг үйл явдал гаргаагүй байна.